



БАТЛАВ. МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ч.БАТЭРДЭНЭ

2017 ОНЫ “ХОЛБООНЫ ЦОМ” ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Тэмцээн **5-7, 8-10, 11-13, 14-16, насанд хүрэгчид** насны ангиллаар охид, хөвгүүд, эр, эм ангиллаар явагдана.
- 1.2. Төрлүүд: **100 буудалт даамын үндсэн, түргэн болон блиц гэсэн 3 төрлөөр** зохиогдоно.
- 1.3. Тэмцээн Монголын даамын холбооны тэмцээний дүрмийн дагуу явагдана.
- 1.4. Тэмцээний дүнг тамирчдын дотоод, гадаад чансаа бодох, зэрэг цол олгоход тооцно.

Хоёр. Тэмцээний журам

- 2.1. Тэмцээн **2017 оны 11 дүгээр сарын 15-наас 19-ны өдрүүдэд** явагдана. Тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч тэмцээнийг байрыг шийдвэрлэн, бүртгэл дууссанаас хойш 7 хоногийн дотор зарлана.
- 2.2. Тамирчдын бүртгэлийг **оролцох эрхийн тоог гүйцтэл эсвэл 2017 оны 11 дугаар сарын 2-ныг хүртэл** хүлээн авна.
- 2.3. **2017 оны тамирчны лицензтэй тамирчид оролцох төрлүүдийн тэмцээний хураамж төлж, тэмцээнд оролцох эрхийг баталгаажуулсан тоглогчид мандат олгоно.**
- 2.4. **Мандатыг 11 дүгээр сарын 13-наас эхлэн олгоно.**
- 2.5. **Тэмцээний хураамжийн хэмжээ**

Цагийн хяналт	
Үндсэн	15,000
Түргэн	10,000
Блиц	10,000

- Тэмцээний хураамжийг дансанд төлснөөр **бүртгэл автоматаар** хийгдэнэ. Өнгөрөгч 7 дугаар сард бүртгүүлсэн тамирчдын бүртгэл хүчинтэй хэвээр байна.
- Дансанд мөнгө тушаахдаа Гишүүний дугаар (эсвэл Регистр), тоглогчийн нэр, оролцох төрлүүдийг гүйлгээний утга дээр бичнэ. Жишээ нь бүх төрөлд оролцох бол 35,000 төг тушааж, “Бүх төрөлд” гэж бичнэ г.м.
- Банкны мэдээлэл:

- **Монголын даамын холбоо, Голомт банк, 1102102442**

- 2.6. Тэмцээний цагийн хяналт талдаа
- Үндсэн төрөл **1 цаг 20 мин**
 - Түргэн **15мин+2сек**
 - Блиц **5мин+2сек**
- 2.7. Швейцарь системээр 7-9 өрөг тоглож дүнг гаргана.
- 2.8. Тоглогчдыг хожлын тоогоор цуваагаар байр эзлүүлэн, хожлын тоо тэнцсэн үед дараах шалгуурыг баримтална. Үүнд:
1. Швейцарь системийн Солкофын коэффициент
 2. Швейцарь системийн медиан Солкофын коэффициент (хоёр талаас нь -2, -3...)

Гурав. Шагнал, урамшуулал

3.1. Тэмцээнд эхний 3 байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар урамшуулна.

3.2. Тамирчин авбал зохих онооноос дараах болзлыг хангасан тохиолдолд спортын цол, зэргийг биелүүлнэ. Үүнд:

Спортын зэргийн болзол

	5-7 нас	8-10 нас	11-13 нас	14-16 нас	Насанд хүрэгчид
Ш зэрэг	12-15 оноо	10-12 оноо	8-10 оноо	6-7 оноо	5-6 оноо
II зэрэг	16 ба түүнээс дээш	13-15 оноо	11-13 оноо	8-10 оноо	7-8 оноо
I зэрэг		16 ба түүнээс дээш	14-16 оноо	11-13 оноо	9 оноо
Дэд мастерын 1 балл			17 ба түүнээс дээш	14-16 оноо	10 оноо
Дэд мастерын 2 балл				17 ба түүнээс дээш	11 оноо
Дэд мастер, СМ 1 балл					12 оноо
СМ 2 балл					13 оноо ба түүнээс дээш

МОНГОЛЫН ДААМЫН ХОЛБОО

Харилцах утас: 99164205, Email: daam@mondaam.mn, Web: www.mondaam.mn

<http://mondaam.mn/2017/tsom/>